



МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН
БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН
БАЙГУУЛЛАГЫН ЗАХИРАЛ НАРТ

МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛНЫ САЙД

15130 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Нэгдсэн үндэслэлийн гудамж 5, Утас: 26-15-53.
Факс: 32-86-84, Цахим шуудан: mlsp@mcs.gov.mn
Цахим хуудас: www.mlsp.gov.mn

2020-04-06 № 1/2022.

ангай _____ ны № _____ -г

Зөвлөмж хүргүүлэх тухай


Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцох журмыг Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 289/А375 дугаар тушаалаар хамтран баталсан.

Уг журамд багшийн сургалтын цагийн ачааллыг бууруулж танхимын сургалтын сургууль дээрх онол, дадлагын 45 цагийг нэг багц цаг гэж тооцож байсныг 36 цаг болгож аргачлалыг өөрчилсөн.

Танхимын бус сургалтын багц цагт багш хөгжихтэй холбоотой, онлайн болон зайн сургалт, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажиллах, багш, суралцагч хамтран шинэ санаа, бүтээл, инноваци бий болгох, багшийн бүтээлч байдлыг дэмжсэн ажил үйлчилгээнүүдийг тусгасан.

Дээрх журмыг хэрэгжүүлэх зөвлөмжийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 6... хуудастай.


С.ЧИНЗОРИГ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2020 оны 04 дүгээр сарын 06 өдрийн
4/10.02 тоот албан бичгийн хавсралт

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцох журмыг хэрэгжүүлэх зөвлөмж

Нэг. Нийтлэг

1.1.Төрийн ба төрийн бус өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагууд багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцохдоо энэхүү зөвлөмжийг мөрдөнө.

1.2.Энэхүү зөвлөмжид заасан “Багц цаг” гэдгийг багшийн сургалт, хөгжилтэй холбоотой бүхий л үйл ажиллагааны багтаамж, хэмжээ, гүйцэтгэл гэж ойлгоно.

1.3.Сургалтын алба нь хичээлийн жилийн эхэнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас баталсан орон тооны хязгаарт багтаан, батлагдсан сургалтын төлөвлөгөөнд үндэслэн багш бүрээр сургалтын цагийн ачаалал, ноогдол цаг, танхимын сургалтын илүү цагийг тооцоолж сургуулийн захирлаар батлуулан мөрдөж ажиллана.

1.4.Багшийн үндсэн цалин ба ур чадварын түвшинээс хамааруулан тогтоосон нэг багц цагийн үнэлгээ харилцан хамааралгүй байна. Үндсэн цалин нэмэгдэх нь нэг багц цагийн үнэлгээг нэмэх үндэслэл болохгүй. Танхимын ба танхимын бус цагийн ачааллын илүү гарсан нэг багц цагийн үнэлгээ ижил байх бөгөөд багц цагийн үнэлгээг тухай сургууль хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан тогтоож шийдвэрлэнэ.

1.5.Нэг багц цагийн үнэлгээ нь танхимын ба танхимын бус илүү багц цагийг олгохтой холбоотой гарч байгаа томъёолол гэдгийг анхаарч, нэг багц цагийн үнэлгээг цалингийн санг хэтрүүлэхгүйгээр бодитой тооцож тогтооно.

1.6.Багшийн тухайн сар, хөгс жил, жилд гүйцэтгэсэн танхимын ба танхимын бус багц цагийн бодит гүйцэтгэлийг багш нараар үнэн зөв гаргуулж холбогдох албан тушаалтан тооцож, сургалтын албаны менежер нэгтгэн хянаж нэгдсэн тооцоог санхүүгийн албанд өгнө.

1.7.Сургалтын албаны менежер нэгтгэн хянах үед тухайн тооцогдсон ажил үйлчилгээ нь хангалтгүй, нотлох баримт дутуу, танхимын бус сургалтын багц цагт хамаарах ажлын жагсаалтад хамаарахгүй ажил үйлчилгээг хасч тооцно.

1.8.Танхимын бус сургалтын багц цагт хамаарах ажил үйлчилгээг бүрэн хангалттай хийсэн тохиолдолд тооцно. Тухайн ажил үйлчилгээ нь бүрэн хангалттай биш, дутуу, зөрчилтэй бол хэсэгчлэн тооцохгүй.

Хоёр. Танхимын бус сургалтын багц цагт хамаарах ажлын жагсаалтыг тооцох

2.1. Сангийн сайд, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын сайдын 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 289/А375 дугаар тушаалаар хамтран баталсан "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцох журам"-ын хоёрдугаар хавсралтаар баталсан ажлын жагсаалтыг баримтална.

2.2. Жагсаалтын дагуу тухайн холбогдох ажил үйлчилгээг тооцохдоо нотлох баримтыг үндэслэл болгоно.

2.3. Тухайн сургалтын байгууллагын холбогдох мэргэжлийн болон сургалт арга зүйн зөвлөлөөр хэлэлцэж зөвшөөрөгдсөн цахим болон хэвлэмэл гарын авлагад танхимын бус сургалтын багц цаг тооцно.

2.4. Сургалтын үндсэн баримт бичиг /стандарт, хөтөлбөр, төлөвлөгөө/ боловсруулахад мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, МБС-ын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвөөр баталгаажсан тохиолдолд багц цаг тооцно. Боловсруулах явцад тодорхой хэмжээний ажлын хөлс, урамшуулал авсан нь тогтоогдсон бол багц цаг тооцохгүй.

2.5. Сургалтын хэрэглэгдэхүүн нь иж бүрдлийн шаардлагыг бүрэн хангасан, сургалтанд хэрэглэгдэж, туршилт, үнэлгээ хийгдсэн бол багц цаг тооцно.

2.6. Лаборатори, дадлагын газар, кабинет /гэрчилгээтэй/ байгуулсан бол тухайн сургалтын байгууллагын ажлын хэсгийн үнэлгээг харгалзан танхимын бус багц цагийг тооцно.

2.7. Дадлагын газар, лаборатори, кабинет хариуцсан байдлыг дадлагын газрын биет үзүүлэн, багаж тоног төхөөрөмжийн хэрэглээ, бүрэн бүтэн байдал, тохижилтийг харгалзаж тооцно.

2.8. Сургалтын орчин бүрдүүлсэн байдал /ангийн эд хогшлын бүрэн бүтэн байдал, ангийн тохижилт/ гэсэн ажил үйлчилгээг зөвхөн онолын хичээл явагддаг анги гэж ойлгож багц цагийг тооцно.

2.9. ХАБЭА-г бүрэн хангаж ажилласан, зөрчилгүй лаборатори, дадлагын газарт ХАБЭА-тай холбоотой багц цагийг тооцно.

2.10. Жижүүр багштай холбогдох багц цагийг ажлын үр дүнгийн үнэлгээгээр тооцно.

2.11. Онлайн сургалттай холбоотой багц цагийг суралцагчийн сэтгэл ханамжийн судалгаа болон сургалтыг баталгаажуулсан бичиг баримтыг үндэслэн тооцно.

2.12. Багш нь төгсөгчдийг ажлын байраар хангасан байх ажил үйлчилгээг тухайн байгууллагын ажилд авсан тушаал, албан бичгийг үндэслэн багц цаг тооцно.

2.13. Нийгмийн хариуцлагын хүрээнд зохиож буй аян, ажил үйлчилгээ, нийтийг хамарсан цэвэрлэгээ, тохижилтод багц цаг тооцохгүй.

2.14. Багш суралцагчдын хяналтын графикийг мөрдөж ажилласан байх ажил үйлчилгээг (давтлага, зөвлөгөө өгөх, бие даалт тооцох явцын шалгалт тооцох) багшийн үндсэн ажлаас гадна хийгдэж, сургалтын албаар баталгаажсан

тохиолдолд багц цаг тооцно. Үндсэн сургалтын ажилд хамаарах бол багц цаг тооцохгүй.

2.15. Web-д суурилсан хичээлтэй холбоотой багц цагийг суралцагчийн хандалт, хэрэглээг үндэслэн тооцно.

2.16. Курсын болон график тооцооны ажил, дипломын төсөл удирдсан байх ажил үйлчилгээг суралцагч амжилттай үнэлэгдсэн тохиолдолд тооцно.

2.17. Мэргэжлийн зэрэг тогтоох шалгалт гэсэн ажил үйлчилгээг аж, ахуйн нэгжээс олгох мэргэжлийн зэргийн шалгалт (төгсөлтийн шалгалт хамаарахгүй) гэж ойлгож үүнд оролцсон мэргэжлийн багшид багц цаг тооцно.

2.18. Багшийн бие даан мэргэжил, боловсролоо дээшлүүлсэн байх ажил үйлчилгээг олгосон гэрчилгээг үндэслэн тооцно. Төрийн захиргааны төв байгууллагын төлөвлөгөөт сургалт, төсөл, хөтөлбөрөөс зохион байгуулсан сургалт, сургуулийн захиргааны холбогдох сургалтууд хамаарахгүй бөгөөд эдгээрт багц цаг тооцохгүй.

Гурав. Багшийн жилийн сургалтын цагийн ачаалал тооцох аргачлал

Нэг. Багшийн жилийн сургалтын цагийн ачаалал тооцох аргачлал

“Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшийн сургалтын цагийн ачааллыг тогтоох, тооцох журам”-ын дагуу багшийн ур чадварын түвшинтэй нь уялдуулан жилийн сургалтын цагийн ачааллыг багш бүрээр тогтооно.

А. 2.5 жилийн болон 1 жилийн сургалттай Мэргэжлийн боловсрол, сургалтын багшийн хувьд:

36 цаг - /онол, лаборатори, сургууль дээрх дадлагын 1 багц цагт ногдох сургалтын төлөвлөгөөний цаг/

18 багц цаг (кредит) - /танхимын сургалтын багц цагт ногдох жилийн сургалтын цагийн ачаалал/

2 багц цаг - /танхимын бус сургалтын багц цагт ногдох жилийн сургалтын цагийн ачаалал/

36 цаг х 18 багц цаг (кредит) = 648 кредит цаг

648 цаг - /багшийн танхимын сургалтын жилийн ачааллыг цагаар тооцсон үзүүлэлт/

36-нэг хичээлийн жилд сургалт явагддаг 7 хоног

648 цаг : 36 = 18 цаг

18 цаг = багшийн долоо хоногийн нормт цаг

Багшийн жилийн сургалтын цагийн ачааллыг ур чадварын түвшинтэй нь уялдуулан тооцвол:

Багшийн ур чадварын түвшин	Танхимын сургалтын багц цаг		Танхимын бус сургалтын багц цаг		1 долоо хоногийн танхимын цагийн норм
	Эзлэх хувь	Жилийн ачааллын багц цаг	Эзлэх хувь	Жилийн ачааллын багц цаг	
Мастер багш	80%	16	20%	4	16 цаг
Ахлах багш	85%	17	15%	3	17 цаг
Багш	90%	18	10%	2	18 цаг
Дадлагажигч багш	95%	19	5%	1	19 цаг

Б. 1.5 жил болон 3 жилийн сургалттай Техникийн боловсрол олгох сургалтын багшийн хувьд:

Энэ сургалтын ангийн хувьд сургууль дээр хичээллэх долоо хоног 32 долоо хоног байдаг.

36 цаг х 18 багц цаг (кредит) = 648 кредит цаг

648 цаг : 32 = 20,25 цаг

20,25 цаг = багшийн долоо хоногийн нормт цаг

Техникийн боловсрол олгох сургалтын багшийн жилийн сургалтын цагийн ачаалал нь ур чадварын түвшингээсээ хамааран Мэргэжлийн боловсрол олгох сургалтын багшийн нэгэн адил байна.

Хоёр.Танхимын сургалтын багц цаг тооцох аргачлал, жишээ

Багш Н.Цэцэгээ нь оёдлын багш мэргэжилтэй, ахлах багш албан тушаалын ур чадварын түвшинтэй гэж үзье. Тэгвэл “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцох журам” –ын дагуу мэргэжлийн /онол ба дадлага/ болон ерөнхий эрдмийн багшийн жилийн цагийн ачаалал нь адил тэгш 20 багц цаг байна. Гэхдээ багшийн ур чадварын түвшингээс хамаарч танхимын ба танхимын бус сургалтын багц цагийн харьцаа өөр байх ёстой. Н.Цэцэгээ ахлах багш учраас дээрх харьцаа нь 85:15 байна. Өөрөөр хэлбэл жилд гүйцэтгэх танхимын сургалтын багц цаг нь 17, танхимын бус сургалтын багц цаг нь 3 багц болно.

Багш Н.Цэцэгээд тухайн хичээлийн жилийн эхэнд танхимын сургалтын дараах ногдол цагийг хуваарилсан байна гэж үзье.Хүснэгт1

Хүснэгт1: Ахлах багш Н.Цэцэгээд хуваарилсан танхимын сургалтын ногдол багц цаг

Д/д	Чадамжийн хичээлийн нэр	нэгж,	Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан цаг:					Нийт цаг	Харгалзах багц цаг	
			Бүгд цаг	Үүнээс:						
				Лекц	Семинар	Лаборатори	Сургууль дээрх дадлага			Үйлдвэрлэлийн дадлага
1	Материал сонгож ашиглах		36	18	18			36	1	
2	ХАБЭА-н шаардлагыг хангах		36	18	18			36	1	
3	Оёдлын үндэсийг судлах		72	18			54	72	2	
4	Ажлын зураг унших		18	6	12			18	0.5	
4	Эсгүүрт бэлтгэх, эсгэх		108	18			54	36	108	2.5
5	Халаас оёх		252	18			108	126	252	5.25
6	Дээл эсгэж, оёх		360	36			198	126	360	8.25
Дүн			882	132	48	0	414	288	882	20.5

Журамд онол /лекц/, семинар, лаборатори, сургууль дээрх дадлагын 36 цагийн бодит гүйцэтгэлийг, үйлдвэрлэлийн ба төгсөлтийн өмнөх дадлагын 72 цагийн бодит гүйцэтгэлийг тус тус 1 багц цаг гэж тооцохоор заасан учраас багш Н.Цэцэгээгийн лекц, семинар, сургууль дээрх дадлагын материал сонгож, ашиглах 36 цаг, ХАБЭА-н шаардлагыг хангах 36 цаг, Оёдлын үндэсийг судлах 72 цаг, Ажлын зураг унших 18 цаг, Эсгүүрт бэлтгэх, эсгэх 72 цаг, Халаас оёх 126 цаг, Дээл эсгэж, оёх 234 цаг нийт 594 цагийг 36 цагаар бодож 16,5 багц цаг гэж тооцлоо. Харин үйлдвэрлэл дээрх дадлагын Эсгүүрт бэлтгэх, эсгэх 36 цаг, Халаас оёх 126 цаг, Дээл эсгэж, оёх 126 цаг нийт 288 цагийг 72 цагаар бодож 4 багц цаг гэж тооцлоо. Өөрөөр хэлбэл нийт танхимын сургалтын багц цаг нь 20,5 багц цаг болж байна.

Гурав.Танхимын бус сургалтын багц цаг тооцох аргачлал, жишээ

МБСБ нь аль ч түвшиний багшид танхимын бус 40 ажил үйлчилгээнээс хангасан үйлчилгээг тооцох боломжтой байгаа.

Багш Н.Цэцэгээ нь ахлах багшийн хувьд жилд танхимын бус сургалтаас 3 багц цаг хангах ёстой.

Багш Н.Цэцэгээ нь танхимын бус ажил үйлчилгээнээс дараах багцуудыг хангасан гэж үзье.

Д/д	Танхимын бус сургалтаар гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний жагсаалт	Тооцсон багц цаг	Тайлбар
1	Гарын авлага бичиж хэвлүүлсэн, хамтран бичсэн бол	0,7	
2	Анги хамт олноо сурлага хүмүүжлийн зөрчилгүй хариуцаж ажилласан байдал	2,0	Сар бүр 0,2 багц цаг тооцуулж ирсэн учир 10 сарын хугацаанд 2 багц цаг тооцуулсан.
3	ЧСС-ын хөтөлбөр, Техникийн боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулж баталгаажуулсан бол	0,4	Өөрийн заадаг 6 хичээлээс 4 нэгж хичээлийн хөтөлбөрийг шинэчилэн боловсруулж, баталгаажуулсан учир 0,4 багц цаг тооцуулсан.
4	Вэб –д суурилсан хичээлийн иж бүрэн электрон хавтас бүрдүүлж, сургалтанд ашигласан /нэг хичээлд/ бол	0,5	Өөрийн заадаг 6 хичээлээс 1 хичээлд электрон сургалтын материал боловсруулж, сургалтандаа ашигласан учраас 0,5 багц цаг тооцсон.
5	Багш нь үндсэн мэргэжлээрээ бие даан мэргэжил боловсролоо дээшлүүлсэн бол	0,4	Үндсэн мэргэжлийн чиглэлээр ажил олгогч дээр мэргэшүүлэх сургалтанд хамрагдаж, бие даан мэргэжил, ур чадвараа дээшлүүлсэн сертификаттай тул 0,4 багц цаг тооцсон.
6	Хөндлөнгийн шалгалтаар сурлагын чанар ахиц гарсан байдал	0,3	Сургуулийн захиргаанаас зааж байгаа хичээлээр суралцагчдаас хөндлөнгийн шалгалт авахад сурлагын чанарт ахиц гарсан учир 0,3 багц цаг тооцуулсан.
Дүн		4,3	

Дөрөв.Багшийн танхимын ба танхимын бус сургалтын багц цагийн жилд гүйцэтгэсэн илүү багц цаг, нэмэгдэл хөлсийг тооцох аргачлал, жишээ

Танхимын ба танхимын бус сургалтын жилд гүйцэтгэсэн багц цагийн ногдлоос давсан багц цагт нэмэгдэл хөлс тооцогдоно.

Багш Н.Цэцэгээ нь танхимын сургалтаас 3,5 багц цаг, танхимын бус сургалтаас 1,3 багц цаг, нийт 4,8 багц цагт нэмэгдэл хөлс тооцуулахаар байна.

Тухайн "Х" сургууль нь ахлах багшийн нэг багц цагийн үнэлгээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан 262000 төгрөгөөр тогтоосон гэж үзье.

Зөвлөмжид тусгасан ёсоор танхимын ба танхимын бус сургалтын нэг багц цагийн хөлс ижил байх ёстой. Багш Н.Цэцэгээ нь жилд нийт 4,8 багц цагийн хөлсийг илүү тооцуулахаар байгаа учраас илүү багц цаг, нэмэгдэл хөлс нь $4,8 * 262000 = 1.257.600$ төгрөг болно.